

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/21 дүгээр зүйлийн 21.3.3 дахь заалт:

“21.3.3.аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх олгох, түүнийг хууль заасан үндэслэлээр хүчингүй болгох, дуусгавар болгох, газрын байршил болон хэмжээ, зориулалт өөрчлөх асуудлыг шийдвэрлэх.”

2/21 дүгээр зүйлийн 21.4.8 дахь заалт:

“21.4.8.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгох, дуусгавар болгох, газрын байршил болон хэмжээ, зориулалт өөрчлөх асуудлыг шийдвэрлэх.”

3/24 дүгээр зүйлийн 24.8 дахь заалт:

“24.8.Хууль, тогтоомжийн дагуу тогтоосон газар ашиглалтын дэглэм, горим бүхий хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газрын болон зам, шугам сүлжээ, ойн сан, усны сан бүхий газар, газрын тос, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн орон зайн мэдээллийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгүүлэх үүрэг хүлээнэ.”

4/33 дугаар зүйлийн 33.9 дахь хэсэг:

“33.9.Энэ хуулийн 33.5-д заасан улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын зориулалтыг бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн онцлогт нийцүүлэн аймаг, Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно.

5/52 дугаар зүйлийн 52.13 дахь хэсэг:

52.13.Энэ хуулийн 52.7-д заасан өвөлжөө, хаваржааны доорх газрын тогтоосон хэмжээнд багтаан өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшүүлж болох газрын дээд хязгаарыг тухайн орон нутгийн газарзүйн онцлог, хүн амын нягтрал, малын тоо, бэлчээр ашиглалтын байдал, газрын нөөцийг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтооно.

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.2.3, 23.2.4 дэх заалт:

“23.2.3.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;”

“23.2.4.улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх;”

2/29 дүгээр зүйлийн 29.3, 29.12 дахь хэсэг:

29.3.Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 хүртэл, мал аж ахуйн салбарт олон жил тогтвортой ажилласан малчин иргэнд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 5 га хүртэл газрыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно.

29.12.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, улс, нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалт болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, улсын тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан нөхөх олговортойгоор газар чөлөөлөх зорилгоор, ахмад настан, нийслэлээс хөдөө орон нутагт шилжин ирсэн, гамшиг ослын улмаас орон гэрээ алдсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд газар эзэмших, ашиглах эрх олгоход энэ хуулийн 29.7, 29.8, 29.9-д заасан эрэмбэлэх дараалал хамаарахгүй.

3/33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг:

“33.5. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт, эсхүл улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор олгоно.”

4/52 дугаар зүйлийн 52.7 дахь хэсэг:

52.7.Өвөлжөө, хаваржааны доорх газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа 1 га хүртэлх газрыг хамтран үнэгүй эзэмшиж болно.

5/58 дугаар зүйлийн 58.7 дахь хэсэг:

58.7.Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа, гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар эзэмшүүлж байгаа газар болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны дүгээр сарын -ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг: